

БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны 07 дугаар сарын 08 – ны өдөр

**АЛБАН ХЭРЭГЦЭЭНД ШААРДЛАГАТАЙ КОМПЬЮТЕР, ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ, ТАВИЛГА ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

БАГЦ-2: ТАВИЛГА /УЛСЫН ХЭМЖЭЭНД/

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолт нь ИНУТ-ийн албан хэрэгцээнд шаардлагатай тавилга /цаашид “бараа” гэх/-ын тодорхойлолт болон тавигдах шаардлага, тоо хэмжээг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартанд нийцсэн шинэ байна.

2.1 Нийлүүлэгчид тавигдах шаардлага

- 2.1.1 Нийлүүлэгч нь стандарт, шаардлагыг хангасан өөрийн агуулахтай байна.
2.1.2 Үйлдвэрийн болон тээвэрлэлтээс үүдэлтэй үүссэн гэмтэл, шинж чанарын өөрчлөлт зэргийг бүрэн хариуцана, зөрчлийг арилгана.
2.1.3 Олон улс, Монгол Улсын чанар стандартын шаардлагыг хангасан үйлдвэрлэгч, нийлүүлэгч болохыг нотлох баримт бичиг ирүүлнэ.

2.2 Бараанд тавигдах шаардлага

- 2.2.1 Чанар стандартын шаардлагыг хангасан өнгө үзэмж сайн, хүснэгтэд өгөгдсөн хэмжээ, загвараар болон түүнээс дээш үзүүлэлттэй байж болно.
2.2.2 Барааны өнгө, загварын талаар захиалагчтай тохиролцсоны үндсэн дээр нийлүүлнэ. Сонголтуудтай фото зураг, танилцуулга ирүүлнэ.
2.2.3 Нийлүүлэх барааны үзүүлэлт, зураг бүхий танилцуулга, угсралтын зааврыг монгол эсхүл англи хэл дээр ирүүлнэ.

3. БАРААНЫ ҮЗҮҮЛЭЛТ, ТОО ХЭМЖЭЭ

Д/Д	Барааны нэр, төрөл	Барааны үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1. Шүүгээ, шкаф					
1.1	Файлын шүүгээ	- 4 шургуулгатай - 9 мм зузаантай сайн чанарын төмрөөр хийгдсэн. - Хэмжээ 120 x 60 x 45см	Ш	5	
2. Сандал					

1.2	Торон сандал (энгийн)	<ul style="list-style-type: none"> - өндөр намын тохируулгатай - нуруу амраагчтай, зөөлөвчтэй түшлэгтэй - хөл нь дугуйтай, эргэдэг - гарын түшлэгтэй - даавуун бүрээстэй - хэмжээ: өндөр 46см, суудал 40 x 50см 	Ш	75	Ажилтны
1.3	Сандал (толгойны түшлэгтэй)	<ul style="list-style-type: none"> - олон тохиргоот налалттай, - нуруу амраагчтай түшлэгтэй - өндөр намын тохируулгатай - хөл, толгой амраагчтай, - хөл нь дугуйтай, эргэдэг - гарын түшлэгтэй - даавуун бүрээстэй - хэмжээ: өндөр 46см, суудал 40 x 50см 	Ш	10	Ээлжийн ажилтны *(Бусад нөхцөл 4.2 заалтыг харна уу)
1.4	Сандал (уулзалтын)	<ul style="list-style-type: none"> - чарган хөл нь бэхэлгээ, даац сайтай - нуруу амраагчтай, зөөлөвчтэй түшлэгтэй - хэмжээ: Өндөр 46см, суудал 40 x 50см 	Ш	16	

4. БУСАД НӨХЦӨЛ

4.1 Монгол улсад мөрдөгддөг стандарт шаардлага хангаж, чанарын гологдолгүй байна.

4.2 Барааны үзүүлэлт, тоо хэмжээ хүснэгтийн 1.3-т заасан сандал нь ээлжийн ажилчид 24 цагаар ашиглахад эдэлгээ даах, бат бөх хийцтэй, өндөр чанартай, суухад тав тухтай байна.

5. ХҮЛЭЭН АВАХ

5.1 Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтийг хангасан барааг нийлүүлнэ.

5.2 Нийлүүлэгч тал барааг тээвэрлэх, зөөхдөө бүрэн бүтэн байдлыг хариуцаж, заасан байрлалд угсарч байрлуулж өгнө.

5.3 ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр барааг хүлээн авсанд тооцно.

5.4 Баталгаат хугацаа нь ажил хүлээн авах комисс нь актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар ба түүнээс дээш байх.

5.5 Ачааг хүргэх цэг: ИНҮТ, ХУД, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар, Монгол Улс

Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү,
эдийн засаг төлөвлөлтийн газрын дарга,
Үнэлгээний хорооны дарга:




Ч.Сэржмаа

Иргэний нисэхийн үндэсний төвийн
Мэдээллийн технологийн хэлтсийн
Программ хангамжийн ахлах инженер,
Үнэлгээний хорооны гишүүн:

Ц.Ган-Эрдэнэ

“ХУД Яармаг” Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



Ж.Бямбасүрэн

“Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл”
Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



Ц.Цэрэндаш

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах
ажиллагааны тасгийн ахлах мэргэжилтэн,
Үнэлгээний хорооны нарийн бичиг:



Б.Мөнхбаатар